
НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗАР



**АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН 2018 ОНЫ УЛСЫН
НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2018 он

АГУУЛГА

1. Тооллогын ажлын үндэслэл, зорилго
2. Хяналт шалгалтын ажил
3. 3-15кВт хүртэл хүчин чадалтай ахуйн хэрэглээний зуухны бүртгэл
4. 15-100кВт хүртэл хүчин чадалтай бага оврын усан халаалтын зуухны бүртгэл
5. 100кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуухны бүртгэл
6. Автотээврийн хэрэгслийн дүн мэдээ

Тооллогын ажлын үндэслэл, зорилго

2018.12.21

Үндэслэл:

Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/181 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 08 өдрийн А/945 дугаар захирамжийг тус тус үндэслэн агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах ажлыг 2018 оны 10 дугаар сарын 8-ны өдөр эхлүүлэн 12 дугаар сарын 15 хүртэл зохион байгуулав.

Зорилго:

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг 215 мянган гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3000 орчим халаалтын зуух гаргаж, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 400 мянга гаруй автотээврийн хэрэгсэл, 6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэрээс ялгарч байгаа утаа, тоос тортог эзэлж байна.

Энэ ажлын зорилго нь агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг цахимжуулах, тэдгээрийн нарийвчилсан мэдээллээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүд тухайлбал янданд шүүлтүүр суурилуулах, түлш солих, зуухыг буулгаж төвийн дулаанд холбох, технологийн шинэчлэл хийх зэрэг боломжит арга хэмжээний саналыг боловрсуулах, үнэлгээ хийхэд оршино.

Тооллогод хамрагдах зуух:

Ахуйн хэрэглээний зуухны MNS-5216:2016 стандарт, 4.2 МВт хүртэл ус халаах зуухны MNS-5043:2016 стандартууд шинэчлэгдэн 2017 оны 04 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн. Дээрх стандартуудыг үндэслэн халаалтын зуухнуудыг дараах байдлаар ангилж байна.

- Ахуйн хэрэглээний 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух (3<чадал<15кВт)
- Ус халаах 15-100кВт хүртэл хүчин чадалтай бага оврын зуух. (15кВт≤чадал<100кВт)
- Ус халаах 100кВт-4.2МВт хүртэл хүчин чадалтай дунд оврын зуух. (100кВт≤чадал<4.2МВт)
- Ус халаах 4.2МВт дээш хүчин чадалтай том оврын зуух. (4.2МВт≤чадал буюу цахилгаан болон дулааны станц)

Хороо, хэсгийн ахлагчдад бага, дунд, том оврын халаалтын зуухыг танихад ойлгомжтой болгох үүднээс зуухны хүчин чадлыг халааж буй талбайн хэмжээнд

үндэслэн тодорхойлох зөвлөмж гаргасан. Тооцооллыг 1м^3 эзэлхүүнийг халаахад 40Вт энерги зарцуулагдана гэж үзсэн.

Зуухны нэршил	Хүчин чадлын халаах талбай	Жишээ
Ердийн галлагаатай 15 кВт хүртлэх хүчин чадалтай зуух	125м² хүртлэх талбайтай гэр байшин халаана.	Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уламжлалт болон сайжруулсан зуух, пийшин, усан халаалтын зуух, мөн жижиг үйлдвэрлэл үйлчилгээ, харуул хамгаалалтын байранд ашиглагдаж байгаа зуух
Усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай зуух	125м²-1000м² талбайтай байшин халаана.	Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уурын болон усан халаалтын зуух
Усан халаалтын 100 кВт дээш хүчин чадалтай зуух	1000м² талбайгаас дээш талбайтай том байр, объект халаана.	Технологийн зориулалттай уур үйлдвэрлэдэг зуух, төвлөрсөн болон нэгдсэн дулаан хангамжийн усан халаалтын зуух

Хүснэгт 1. Зуухны ангилал, халаах талбайн хэмжээ



Зураг 1. 125 м²-аас доош талбайг халааж буй ахуйн хэрэглээний зуух



Зураг 2. 125 м2-аас дээш талбайг халааж буй нам даралтын усан халаалтын зуух



Зураг 3. Гэр хороололд байрлах сургууль, цэцэрлэг, буудал гэх мэт томоохон объектуудыг халааж буй уурын болон усан халаалтын 100кВт-4МВт хүртлэх хүчин чадалтай зуух

Мэдээллийн сан:

Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлыг дараах схемээр зохион байгуулдаг бөгөөд цахим мэдээллийн сан ашигласанаар мэдээлэл хурдан шуурхай дамжигдах, бусад байгууллагуудын үүрэг оролцоо, хяналт нэмэгдэх, мэдээллийн чанар сайжрах давуу талтай юм.



Тооллогын ажлын үр дүнд дараах өгөгдлүүд бүхий мэдээллийн сан үүснэ.

Үүнд:

- Дүүргийн нэр
- Хорооны дугаар
- Хэсгийн дугаар
- Уртраг, Өргөрөг
- Зуухны марк
- Үйлдвэрлэсэн улс
- Суурилуулсан болон ашиглалтанд орсон огноо
- Усан халаалтын зуухны чадал /кВт/
- Халаах талбай /м2/
- Ашиглаж буй байдал /үндсэн эсвэл нөөцөнд/
- Ашиглаж буй нүүрсний уурхайн нэр
- Жилд хэрэглэсэн түлшний хэмжээ /тн/
- Үнс баригч байгаа эсэх
- Үнс баригч төхөөрөмжийн марк
- Үнс баригч суурилуулсан огноо
- Үнс баригч төхөөрөмжийн ашигт үйлийн коэффициент
- Яндангийн төрөл /дугуй эсвэл дөрвөлжин/

-
- Яндан нь сорьцын цэгтэй эсэх
 - Яндан нь малгайтай эсэх
 - Яндангийн өндөр
 - Дөрвөлжин яндангийн амсрын хэмжээ /см/
 - Дугуй яндангийн диаметр /см/
 - Нүүрс хадгалах талбайн хэмжээ /м2/
 - Үнс хаях талбайн хэмжээ /м2/
 - Жилд гарах үнсний хэмжээ /тн/
 - Хаягдлыг зайлуулах хэлбэр /өөрсдөө, ТҮК эсвэл бусад/
 - Зуух, яндангийн зураг

3-15КВТ ХҮРТЭЛ ХҮЧИН ЧАДАЛТАЙ АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗУУХНЫ ТООЛЛОГО

Тооллогын ажлыг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 12 дугаар сарын 15 хооронд нийслэлийн 9 дүүрэгт зохион байгууллаа. Тооллогын дүнг дүүрэг тус бүрээр гаргавал:

Баянгол дүүрэг

Баянгол дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 6176 ахуйн хэрэглээний зуух тоологдсон.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Баянгол	1-р хороо	1	0	1
2	Баянгол	2-р хороо	0	1	1
3	Баянгол	3-р хороо	1	2	3
4	Баянгол	4-р хороо	9	6	15
5	Баянгол	5-р хороо	2	1	3
6	Баянгол	6-р хороо	1	1	2
7	Баянгол	7-р хороо	6	4	10
8	Баянгол	8-р хороо	1	1	2
9	Баянгол	9-р хороо	231	257	488
10	Баянгол	10-р хороо	152	1002	1154
11	Баянгол	11-р хороо	288	427	715
12	Баянгол	13-р хороо	0	1	1
13	Баянгол	16-р хороо	82	70	152
14	Баянгол	18-р хороо	9	0	9
15	Баянгол	19-р хороо	1	2	3
16	Баянгол	20-р хороо	121	114	235
17	Баянгол	21-р хороо	663	557	1220
18	Баянгол	22-р хороо	561	523	1084
19	Баянгол	23-р хороо	484	594	1078
Баянгол дүүрэгт			2613	3563	6176

Хүснэгт 2. Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Баянзүрх дүүрэг

Баянзүрх дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 26946 ахуйн хэрэглээний зуух тоологдсон. Хаягандаа байхгүй 9516 өрх, цахилгаан халаагууртай 2049 өрх, дахин төлөвлөлтөөр нүүсэн 2747 өрх тооллогод хамрагдаагүй байна.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Баянзүрх	1-р хороо	1		1
2	Баянзүрх	2-р хороо	651	609	1260
3	Баянзүрх	4-р хороо	563	355	918
4	Баянзүрх	5-р хороо	1076	675	1751
5	Баянзүрх	6-р хороо		2	2
6	Баянзүрх	7-р хороо		1	1
7	Баянзүрх	8-р хороо	757	457	1214
8	Баянзүрх	9-р хороо	1431	717	2148
9	Баянзүрх	10-р хороо	567	220	787
10	Баянзүрх	11-р хороо	1140	586	1726
11	Баянзүрх	12-р хороо	945	530	1475
12	Баянзүрх	13-р хороо	475	371	846
13	Баянзүрх	14-р хороо	245	110	355
14	Баянзүрх	16-р хороо	55	44	99
15	Баянзүрх	17-р хороо	1035	194	1229
16	Баянзүрх	19-р хороо	1491	207	1698
17	Баянзүрх	20-р хороо	1167	132	1299
18	Баянзүрх	21-р хороо	782	483	1265
19	Баянзүрх	22-р хороо	1008	632	1640
20	Баянзүрх	23-р хороо	1120	711	1831
21	Баянзүрх	24-р хороо	838	495	1333
22	Баянзүрх	27-р хороо	1618	469	2087
23	Баянзүрх	28-р хороо	1241	740	1981
Баянзүрх дүүрэгт			18206	8740	26946

Хүснэгт 3. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгээр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Сонгинохайрхан дүүрэг

Сонгинохайрхан дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 47334 ахуйн хэрэглээний зуух тоологдсон. Эзэнгүй 14708 өрх, цахилгаан халаагууртай 1765 өрх, дахин төлөвлөлтөөр нүүсэн 860 өрх тооллогод хамрагдаагүй байна.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Сонгинохайрхан	1-р хороо	2007	899	2906
2	Сонгинохайрхан	2-р хороо	1904	863	2767
3	Сонгинохайрхан	3-р хороо	1311	649	1960
4	Сонгинохайрхан	4-р хороо	697	462	1159
5	Сонгинохайрхан	5-р хороо	685	442	1127
6	Сонгинохайрхан	6-р хороо	716	513	1229
7	Сонгинохайрхан	7-р хороо	1841	1109	2950
8	Сонгинохайрхан	8-р хороо	776	542	1318
9	Сонгинохайрхан	9-р хороо	858	503	1361
10	Сонгинохайрхан	10-р хороо	1485	702	2187
11	Сонгинохайрхан	11-р хороо	1068	610	1678
20	Сонгинохайрхан	20-р хороо	369	65	434
21	Сонгинохайрхан	21-р хороо	1699	25	1724
22	Сонгинохайрхан	22-р хороо	4237	1424	5661
23	Сонгинохайрхан	23-р хороо	1291	868	2159
24	Сонгинохайрхан	24-р хороо	2412	1436	3848
25	Сонгинохайрхан	25-р хороо	1679	935	2614
26	Сонгинохайрхан	26-р хороо	2665	1339	4004
27	Сонгинохайрхан	27-р хороо	55	33	88
28	Сонгинохайрхан	28-р хороо	1084	398	1482
30	Сонгинохайрхан	30-р хороо	699	393	1092
31	Сонгинохайрхан	31-р хороо	1398	943	2341
32	Сонгинохайрхан	32-р хороо	997	248	1245
Сонгинохайрхан дүүрэгт			31933	15401	47334

Хүснэгт 4. Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Сүхбаатар дүүрэг

Сүхбаатар дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 10325 ахуйн хэрэглээний зуух тоологдсон. Эзэнгүй 1068 өрх, хаягандаа байхгүй 6814 өрх, цахилгаан халаагууртай 858 өрх тооллогод хамрагдаагүй байна.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Сүхбаатар	1-р хороо		1	1
2	Сүхбаатар	2-р хороо	2		2
3	Сүхбаатар	4-р хороо	5	2	7
4	Сүхбаатар	5-р хороо	2	4	6
5	Сүхбаатар	6-р хороо	2	6	8
6	Сүхбаатар	9-р хороо	389	338	727
7	Сүхбаатар	11-р хороо	205	150	355
8	Сүхбаатар	12-р хороо	565	398	963
9	Сүхбаатар	13-р хороо	506	597	1103
10	Сүхбаатар	14-р хороо	369	419	788
11	Сүхбаатар	15-р хороо	373	509	882
12	Сүхбаатар	16-р хороо	1062	728	1790
13	Сүхбаатар	17-р хороо	636	448	1084
14	Сүхбаатар	18-р хороо	666	675	1341
15	Сүхбаатар	19-р хороо	144	146	290
16	Сүхбаатар	20-р хороо	473	505	978
Сүхбаатар дүүрэгт			5399	4926	10325

Хүснэгт 5. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Хан-Уул дүүрэг

Хан-Уул дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 11392 ахуйн хэрэглээний зуух тоологдсон. Цахилгаан халаагууртай 871 өрх тооллогод хамрагдаагүй байна.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
2	Хан-Уул	2-р хороо	5	2	7
3	Хан-Уул	3-р хороо	29	1	30
4	Хан-Уул	4-р хороо	546	315	861
5	Хан-Уул	5-р хороо	544	253	797
6	Хан-Уул	6-р хороо	651	352	1003
7	Хан-Уул	7-р хороо	616	243	859
8	Хан-Уул	8-р хороо	943	711	1654
9	Хан-Уул	9-р хороо	959	590	1549
10	Хан-Уул	10-р хороо	501	304	805
11	Хан-Уул	11-р хороо	164	98	262
12	Хан-Уул	12-р хороо	559	191	750
13	Хан-Уул	13-р хороо	744	161	905
14	Хан-Уул	14-р хороо	617	257	874
16	Хан-Уул	16-р хороо	419	617	1036
Хан-Уул дүүрэгт			7297	4095	11392

Хүснэгт 6. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Чингэлтэй дүүрэг

Чингэлтэй дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 18151 ахуйн хэрэглээний зуух тоологдсон. Эзэнгүй 6492 өрх, хаягандаа байхгүй 4903 өрх, цахилгаан халаагууртай 666 өрх тооллогод хамрагдаагүй байна.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
6	Чингэлтэй	6-р хороо	4		4
7	Чингэлтэй	7-р хороо	1365	643	2008
8	Чингэлтэй	8-р хороо	359	236	595
9	Чингэлтэй	9-р хороо	455	488	943
10	Чингэлтэй	10-р хороо	529	407	936
11	Чингэлтэй	11-р хороо	397	372	769
12	Чингэлтэй	12-р хороо	1690	986	2676
13	Чингэлтэй	13-р хороо	796	398	1194
14	Чингэлтэй	14-р хороо	578	372	950
15	Чингэлтэй	15-р хороо	823	505	1328
16	Чингэлтэй	16-р хороо	1594	725	2319
17	Чингэлтэй	17-р хороо	761	602	1363
18	Чингэлтэй	18-р хороо	906	509	1415
19	Чингэлтэй	19-р хороо	956	695	1651
Чингэлтэй дүүрэгт			11213	6938	18151

Хүснэгт 7. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Налайх дүүрэг

Налайх дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 5631 ахуйн хэрэглээний зуух тоологдсон.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Налайх	1-р хороо	897	192	1089
2	Налайх	2-р хороо	418	31	449
3	Налайх	3-р хороо	933		933
4	Налайх	4-р хороо	1047	18	1065
5	Налайх	5-р хороо	429	19	448
6	Налайх	6-р хороо	547	11	558
7	Налайх	7-р хороо	755	84	839
Налайх дүүрэгт			5026	355	5381

Хүснэгт 8. Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Багануур дүүрэг

Багануур дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 2216 ахуйн хэрэглээний зуух тоологдсон.

№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Багануур	1-р хороо	322	7	329
2	Багануур	2-р хороо	81	11	92
3	Багануур	3-р хороо	369	10	379
4	Багануур	4-р хороо	555	59	614
5	Багануур	5-р хороо	746	56	802
Багануур дүүрэгт			2073	143	2216

Хүснэгт 9. Багануур дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Багахангай дүүрэг

Багахангай дүүрэгт 3-15 кВт хүртэл хүчин чадалтай нийт 392 ахуйн хэрэглээний зуух тоологдсон.


№	Дүүрэг	Хороо	ердийн	сайжруулсан	нийт
1	Багахангай	1-р хороо	115	6	121
2	Багахангай	2-р хороо	269	2	271
Багахангай дүүрэгт			384	8	392

Хүснэгт 10. Багахангай дүүргийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны тоо

Нийт 128313 ахуйн хэрэглээний зуухны бүртгэлээр мэдээллийн сан үүсгэсэн ба тооллогод хамрагдаагүй өрхийн тоог утаат өрхийн тоонд оруулан нийт эх үүсвэрийн тоог гаргасан. Нийслэлийн хэмжээнд нийт 171814 ахуйн хэрэглээний зуух бүртгэгдсэн байна.

№	Дүүрэг	Цахим системд бүртгэгдсэн			Бүртгэлд хамрагдаагүй өрхийн тоо	Нийт зуухны тоо	Жилийн нүүрсний зарцуулалт /тн/
		Ердийн зуухтай	Сайжруулсан зуухтай	Нийт			
1	Багануур	2,073	143	2,216		2,216	8,864
2	Багахангай	384	8	392		392	1,568
3	Баянгол	2,613	3,563	6,176		6,176	24,704
4	Баянзүрх	18,206	8,740	26,946	9,516	36,462	145,848
5	Налайх	5,026	355	5,381		5,381	21,524
6	Сонгинохайрхан	31,933	15,401	47,334	14,708	62,042	248,168
7	Сүхбаатар	5,399	4,926	10,325	7,882	18,207	72,828
8	Хан-Уул	7,297	4,095	11,392		11,392	45,568
9	Чингэлтэй	11,213	6,938	18,151	11,395	29,546	118,184
Улаанбаатар хот		84,144	44,169	128,313	43,501	171,814	687,256

Хүснэгт 11. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх бүртгэгдсэн ахуйн хэрэглээний зуухны мэдээлэл



Зураг 4. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны байршил

АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ

Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлын явцад хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу хяналт шалгалтын ажлыг 2018 оны 11 дүгээр сарын 20-30 өдрийн хооронд гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын ажлаар тус газрын мэргэжилтнүүд дүүргүүдэд хуваарилагдан ажилласан.

Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд мэргэжилтэн Г.Бат-Оюун, Л.Нармандах, У.Жаргалбаатар нар, Баянгол дүүрэгт мэргэжилтэн Ж.Рэнцэнханд, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд мэргэжилтэн О.Алангэрэл, Сонгинохайрхан дүүрэгт мэргэжилтэн Б.Мөнхсайхан, Сүхбаатар дүүрэгт мэргэжилтэн Н.Насанжаргал, Чингэлтэй дүүрэгт мэргэжилтэн Д.Санчирбаяр нар ажилласан. Хяналт шалгалтын ажлын явцад дараах хүндрэл, бэрхшээл тулгарч буйг дүүрэг хорооны мэргэжилтнүүд хэлж байсан. Үүнд:

1. Ухаалаг утасны аппилейкшн нь зарим үед гацдаг
2. Ухаалаг гар утастай хэсгийн ахлагч ховор учир цаасан дээр бүртгэсэн
3. Хороон дээр ирж шивж оруулсан зүйл давхардсан эсвэл орохгүй байх
4. Газрын зураг дээрх байршил тогтоогдохгүй
5. Цаас, принтерийн хор хүрэлцэхгүй байгаа
6. Эрт харанхуй болж байгаа учир олон айлаар орж чадахгүй байгаа
7. Айлын нохойнд уруулах эрсдэлтэй байсан гэх мэт хүндрэлүүд байгаа тухай ярьж байсан.

Мөн өрхийн статистик тоо бүртгэлтэй тоо хэмжээ нь тулахгүй, хаягандаа байхгүй айл их, эзэнгүй айлд бүртгэл явуулах боломжгүй байсан зэрэг тооллогыг бүрэн гүйцэт явуулахад хүндрэл гарч байсан.

Дээрх бэрхшээлүүдээс засаж залруулах боломжтой асуудлуудыг газар дээр нь засаж залруулан ажилласан. Тухайлбал гар утасны аппилейкшны ажиллагаа, дамжуулалтын адлаа, програмд шивж оруулахад мэдээллийг зөв оруулах заавар зөвөлгөө, цаас принтерийн хорны асуудлуудыг шийдвэрлэсэн.





Зураг 5. Хяналт шалгалтын ажлын явцын зураг

Хяналт шалгалтын ажлын хүрээнд алслагдсан 3 дүүргийн 100кВт-аас дээш зуухны бүртгэл тооллогын ажлыг давхар хийсэн. Багануур дүүрэгт 100 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын 1 сургуулийн 1 зуух, Багахангай дүүрэгт 2 аж ахуйн нэгж, байгууллагын 11 зуух, Налайх дүүрэгт 9 аж ахуйн нэгж, байгууллагын 27 зуухыг бүртгэл тооллогод хамруулж бүртэглээ.



Зураг 6. Хяналт шалгалтын ажлын хүрээнд 100кВт-аас дээш хүчин чадалтай зуухыг бүртгэл тооллогод хамруулах үеийн зураг

АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг нягтлах үүднээс хяналтын тооллоогыг Хан-Уул дүүргийн 10-р хороо, Морингийн давааны хэсгийн айлуудад хийсэн. Бүртгэл тооллогын ажлаар Хан-Уул дүүргийн 10-р хороо, 1,2,3-р хэсэг, Морингийн давааны 0-15-р гудамжинд нийт 493 айл тоологдсон байна. Хяналтын тооллогоор 591 айл тоологдсон ба нийт зуухны 83.4% нь тооллогод хамрагджээ. Иймд нийт тооллогын дүнг 1.2 коэффициентоор нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэн нийт өрхийн тоог өсгөж тооцлоо.

№	Дүүрэг	Цахим системд бүртгэгдсэн			Бүртгэлд хамрагдаагүй өрхийн тоо	Нийт зуухны тоо	Жилийн нүүрсний зарцуулалт /тн/
		Ердийн зуухтай	Сайжруулсан зуухтай	Нийт			
1	Багануур	2,488	172	2,659		2,659	10,637
2	Багахангай	461	10	470		470	1,882
3	Баянгол	3,136	4,276	7,411		7,411	29,645
4	Баянзүрх	21,847	10,488	32,335	11,419	43,754	175,018
5	Налайх	6,031	426	6,457		6,457	25,829
6	Сонгинохайрхан	38,320	18,481	56,801	17,650	74,450	297,802
7	Сүхбаатар	6,479	5,911	12,390	9,458	21,848	87,394
8	Хан-Уул	8,756	4,914	13,670		13,670	54,682
9	Чингэлтэй	13,456	8,326	21,781	13,674	35,455	141,821
Улаанбаатар хот		100,973	53,003	153,976	52,201	206,177	824,707

Хүснэгт 12. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ахуйн хэрэглээний зуухны мэдээлэл


**15-100КВТ ХҮРТЭЛ ХҮЧИН ЧАДАЛТАЙ БАГА ОВРЫН
УСАН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ БҮРТГЭЛ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.6, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын “Аз жаргалтай Улаанбаатар” хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 08 өдрийн А/398 дугаар захирамжийг тус тус үндэслэн бага, дунд оврын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллогыг 2018 оны 6 дугаар сарын 14-ны өдрөөс 30 хооронд нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан ба энэ тооллогын дүнг улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлын хүрээнд дахин баталгаажуулсан. Тооллогын дүнг нэгтгэн үзүүлбэл дараах байдалтай байна.

№	Дүүрэг	Зуухны тоо	Яндангийн хэлбэр		Үнс баригч төхөөрөмж тэй	Яндан нь сорьцын цэгтэй	Яндан нь малгайтай
			Дугуй	Дөрвөлжин			
1	Баянгол	243	237	6	64	5	6
2	Баянзүрх	507	485	22	154	43	51
3	Сонгино хайрхан	591	567	24	201	58	81
4	Сүхбаатар	280	259	21	87	17	37
5	Хан-Уул	323	305	18	78	20	20
6	Чингэлтэй	389	363	26	162	24	36
7	Багануур	8	7	1	3	0	0
8	Багахангай	11	11	0	2	1	0
9	Налайх	45	41	4	11	2	6
	Нийт	2397	2275	122	762	170	237

Хүснэгт 12. Нийслэлийн 15-100кВт хүртэл хүчин чадалтай зуухны нэгтгэл

Тооллогыг газарзүйн координаттай бүртгэж буй тул халаалтын зуухнуудын байршил, төвлөрөл, цахилгаан дулааны системд холбогдох боломж зэрэгт дүгнэлт гаргах боломж бүрдэж байна.



Зураг 7. Нийт төвийн 6 дүүрэгт байрлах 15-100 кВт хүчин чадалтай халаалтын зуух

100кВТ-ААС ДЭЭШ ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ БҮРТГЭЛ

2017 – 2018 онд 100кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг ААНБ-ын магадлан итгэмжлэх хяналт шалгалтын ажил, агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт нийт 200 аж ахуйн нэгж байгууллагын 384 халаалтын зуух бүртгэгдэв. Дээрх ажлуудын хүрээнд Баянгол дүүрэгт 8 аж ахуйн нэгжийн 9 зуух, Баянзүрх дүүрэгт 65 аж ахуйн нэгжийн 123 зуух, Сонгинохайрхан дүүрэгт 36 аж ахуйн нэгжийн 72 зуух, Сүхбаатар дүүрэгт 16 аж ахуйн нэгжийн 29 зуух, Хан-Уул дүүрэгт 36 аж ахуйн нэгжийн 66 зуух, Чингэлтэй дүүрэгт 27 аж ахуйн нэгжийн 46 зуух, Багануур дүүрэгт 1 аж ахуйн нэгжийн 1 зуух, Багахангай дүүрэгт 2 аж ахуйн нэгжийн 11 зуух, Налайх дүүрэгт 9 аж ахуйн нэгжийн 27 зуух хамрагдаж бүртгэгдлээ.

№	Дүүрэг	Байгууламжын тоо	Зуухны тоо	Яндангийн тоо	Утааны хэмжилт хийгдсэн
1	Багануур	1	1	1	0
2	Багахангай	2	11	11	0
3	Баянгол	8	9	8	2
4	Баянзүрх	65	123	101	16
5	Налайх	9	27	27	0
6	Сонгинохайрхан	36	72	60	10
7	Сүхбаатар	16	29	27	17
8	Хан-Уул	36	66	50	5
9	Чингэлтэй	27	46	40	6
Улаанбаатар хот		200	384	325	56

Хүснэгт 13. 100кВт дээш хүчин чадалтай усан халаалтын зуухны нэгтгэл

ААНБ-ын ашиглаж буй зуухны үйлдвэрлэсэн улс, тоогоор

Улаанбаатар хотод ашиглагдаж буй нийт зуухны хувьд хятад улсад үйлдвэрлэгдсэн зуух 33.6 хувь, Чех улсад үйлдвэрлэгдсэн зуух 10,0 хувь, Солонгос улсад үйлдвэрлэгдсэн зуух 16.2 хувь, Орос улсад үйлдвэрлэгдсэн зуух 4.05 хувь, Унгар улсад үйлдвэрлэгдсэн зуух 10,5 хувь ашиглагдаж байна. Харин Монгол улсад үйлдвэрлэгдсэн зуух 25,5 хувь ашиглаж байгаа нь хэрэглээний хувьд Хятад улсад үйлдвэрлэгдсэн зуухны ашиглалтын дараа орж байгаа юм.

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДҮН МЭДЭЭ

Аймаг/хот	Улаанбаатар	Хувь
Суудал	397349	79.20
Ачаа	76740	15.30
Автобус	4526	0.90
Тусгай	7927	1.58
Цистерн	2994	0.60
Зүтгүүр	12147	2.42
Автомашин - нийт тоо	501683	100

Хүснэгт 14. Тээврийн хэрэгслийн тоо, автомашины төрлөөр

Автомашины насжилтаар авч үзвэл

- 0-3 настай 3.13%
- 4-6 настай 6.4%
- 7-9 настай 16.43%
- 10 ба түүнээс дээш настай 74.05% байна.

Шатахууны төрлөөр авч үзвэл

- Бензин хөдөлгүүртэй 49.63%
- Дизель хөдөлгүүртэй 22.93%
- Газ хөдөлгүүртэй 2.48%
- Хосолсон хөдөлгүүртэй 24.92%
- Цахилгаан хөдөлгүүртэй 0.03%-тай байна.

ТАНИЛЦСАН: НАББГ-ын дарга

Б.Цацрал

ХЯНАСАН: АЧХХ-ийн дарга

Х.Галымбек

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжилтэн

Л.Нармандах